



ÀÐÕÀÍ ÀÀÉ ÀÉÌ ÀÈÉÍ
ÑÒÀÒÈÑÒÈÈÈÉÍ ÕÝÈÕÝÑ

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2017/12





ӨРХ ХҮН АМ

2017 оны эцэст манай аймаг 27,5 мянган өрх, 94,9 мянган хүн амтай байна. Өрх хүн амыг байршлаар нь авч үзвэл нийт өрхийн 20,1 хувь нь буюу 5,5 мянган өрх, хүн амын 19,0 хувь буюу 18,1 мянган хүн сумын төвд, 21,3 хувь буюу 5,9 мянган өрхийн 21,6 мянган хүн аймгийн төвд оршин сууж байна.

Нийт өрхийн дотор 6 ба түүнээс дээш гишүүнтэй өрх 1,4 мянга, 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 2,0 мянга байна. 1577 ганц бие өндөр настан өрх байгаагийн 68,7 хувь нь 55 ба түүнээс дээш насны эмэгтэй байна. Аймгийн дүнгээр өрхийн дундаж ам бүл 3,4, хүн амын нягтрал 1 км²-д 1,7 байна.

Нийт хүн амын 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж хүйсийн харьцаа 100,4 байна. Насны хувьд нийт хүн амын 33.4 хувийг 0-16 насны хүүхдүүд, 32,1 хувийг 17-35 насны залуучууд, 6,8 хувийг 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Аймгийн хэмжээгээр 90-99 настай 79 хүн, 100-аас дээш настай 6 хүн байна.

Аймгийн хэмжээнд 1872 өнчин хүүхэд байгаагийн 6,2 хувь нь бүтэн өнчин хүүхдүүд байгаа ба нийт өнчин хүүхдийн 26,4 хувийг 0-9 насны хүүхдүүд эзэлж байна.

Өрх толгойлсон 2734 эмэгтэйчүүд байгаагийн 4,1 хувь нь 6 ба түүнээс дээш ам бүлийг тэжээж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 3523 хүн байгаагаас 1513 нь эмэгтэй, 1463 нь төрөлхийн тахир дутуу хүмүүс байна.



СОЁЛ УРЛАГ, БОЛОВСРОЛ

Хөгжимт драмын театр 2017 онд 7 уран бүтээл шинээр хийж 59 удаа тоглолт зохион байгуулан давхардсан тоогоор 36,0 мянган хүнд үйлчилж урын сандаа 38 бүтээлтэй

байна.Өнгөрсөн оныхоос тоглолт, үзэгчдийн тоо 1,7-7,2 хувиар өссөн байна.

Аймгийн музейн хамт олон 3,9 мянган үзмэрээр 6,1 мянган хүнд үйлчилж 7,7 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын хэмжээ 1,3 хувиар өссөн байна

Төв хөдөөгийн болон сургуулиудын 50 номын сан 75,0 мянган хүнд давхардсан тоогоор 333,1 мянган номоор үйлчилж оны эцэст 650,8 мянган ширхэг номын фондтой байна.

Сумдын соёлын төвүүд 2520 удаа урлаг, уран сайхны ажил зохиож түүнд давхардсан тоогоор 227.0 мянган хүн хамрагдаж 40,0 сая төгрөгийн орлоготой ажиллав.

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 33 сургуулийн 669 бүлэгт 17,3 мянган хүүхэд суралцаж, 36 цэцэрлэгт 7,3 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.9 мянган хүүхэд, 10-р ангид 1,0 мянган хүүхэд элссэний гадна 2.3 мянган хүүхэд ЕБСургуулийн дотуур байранд сууж байна.

Манай аймагт эдийн засгийн чиглэлийн 1 дээд сургууль ажиллаж түүнд 74 оюутан, Багшийн коллежид 494 оюутан суралцаж байна. Аймгийн төвийн төрийн болон хувийн хэвшлийн гурван МСҮТөвд талх нарийн боовчин, тогооч, үсчин гоо сайханч, ХАА, хүлэмжийн аж ахуйн фермерч, компьютер албан хэрэг хөтлөгч, оёдол эсгүүрчин, автомашины болон цахилгаан хэрэгслийн засварчин, сантехникч гагнуурчин, барилгын өрлөг болон засал чимэглэгч, малын бага эмч, санитори, санхүүгийн туслах ажилтан зэрэг 15 гаруй төрлийн мэргэжлээр 1101 хүүхэд суралцаж байна.




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 518 ор, амбулаторийн 101 их

эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 294,4 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 119,9 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 20,0 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.


Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98,8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100,0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Тайлант онд 1890 эхээс 1902 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 2,8 хувиар буюу 55 хүүхдээр бага байна,

Хүн амын нас баралт 449 гарсан нь өнгөрсөн оныхоос 39 тохиолдлоор буюу 8,0 хувиар бага байна. Мянган хүнд ноогдох төрөлт 20,3, нас баралт 4,8 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 15,5 промил байна. Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7 гарч мянган амьд төрөлтөд 3,7 ноогдож өнгөрсөн оныхоос 10 тохиолдлоор буурсан байна.



Нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 32 гарч мянган амьд төрөлтөд 16,8 ногдож байгаа нь өнгөрсөн оныхоос 5 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 47 нь буюу 491 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган(87), Ихтамир(88), Эрдэнэмандал (61), Жаргалант (59), , Өндөрүлаан (51) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 2,0 хувь нь гепатит, 21,0 хувь нь салхин цэцгээр, 1,2 хувь нь улаан бурханаар, 39,7 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 10,4 хувь нь сүрьеэгээр, 25,7 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 3,0 дахин буюу 979 тохиолдлоор буурсан байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР


12 дугаар сарын 31-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа

1617 ажилгүй хүн байгаагийн 49,1 хувь нь буюу 794 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 289 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оныхоос бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 20,8 хувиар нэмэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98,2 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 296 нь дээд, 72 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 1131 нь бүрэн болон бүрэн бус дунд, 89 нь бага боловсролтой хүмүүс байна.

12 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 501 хүн шинээр бүртгүүлж, 140 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж, 151 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Энэ онд аймгийн дүнгээр 1399 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар авч үзвэл Эрдэнэбулгансум 289, Чулуут, Цахир, Эрдэнэмандал сумд 99-123 ажлын байрыг, Ихтамир, Өгийнуур, Жаргалант, Тариат, Цэнхэр, Төвшрүүлэх, Булган, Хангай сумд 58-86 ажлын байрыг, Хашаат, Өндөрүлаан, Хотонт, Өлзийт, Батцэнгэл сумд 22-39 ажлын байрыг, Хайрхан, Цэцэрлэг сумд 13-16 ажлын байрыг тус тус бий болгосон байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо





НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 онд 47,7 тэрбум төг, зарлага 47,4 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 2192,6 сая төг буюу 4,4 хувь, зарлага 2891,3 сая төг буюу 5,8 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 2192,6 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн даатгалын сангийн орлого 5,2 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 1,8 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 0,3 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 11,1 хувиар тус тус буурсан нь нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 5,8 хувиар буурахад тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн даатгалын сангууд 0,5-11,6 хувиар буурсан нь голлон нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 39,7 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1,6 тэрбум төгрөгийг олгосон байна.

Энэ онд нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 25,2 мянган хүнд 11160,3 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 60,1 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 39,9 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 51,0 хувийг халамжийн тэтгэврээр, 28,0 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 21,0 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.


Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц



ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 350 холбогдогч бүхий 514 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 162, өмчлөх эрхийн эсрэг 262, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 44, байгаль хамгаалах журмын эсрэг 15, бусад 31 хэрэг гарсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо




Гэмт хэргийн улмаас 31 хүн нас барж, 188 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 1358,0 сая төгрөгийн хохирол

учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 9,4 хувийг бүлэглэж, 28,3 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 798 хүнийг албадан саатуулж 180 хүнийг баривчилсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 4,1 хувиар буюу 22 тохиолдлоор буурсны дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 6,9 хувиар буюу 12 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 8,0 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2017 онд аймгийн төсөвт 21552.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 23208.3 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 105,1 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 8845,8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 10501,6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 118,7 хувиар биелүүллээ.

Төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумд 105,6 -231,1 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл хүү, торгуулийн орлого, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, тусламжийн орлогоос бусад нэрийн орлогуудыг 105,1 – 280,3 хувиар биелүүлсэн байна.


Аймгийн төсвийн орлогын 54,8 хувийг тусламжийн орлогоор, 21,5 хувийг орлогын албан татвараар, 1,4 хувийг өмчийн татвараар, 1,2 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 15,9 хувийг бусад албан татвараар, 4,1 хувийг татварын бус орлогоор, 1,1 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 298,6 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 816,2 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 407,5 агаарын бохирдлын төлбөрөөр 26,8 сая төгрөг бүгд 1549,0 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 65348,1 сая төгрөг байгаагийн 45,6 хувийг цалин хөлсөнд, 5,0 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 49,4

хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 40,3 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 49,7 хувийг боловсролын салбарт, 9,2 хувийг эрүүл мэндийн салбарт, 0,4 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0,4 хувийг бусад салбарт зарцууллаа.

**Орон нутгийн төсвийн байгууллагын
нийт зарлагын бүтэц, хувиар**




МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 15,8 тэрбум төгрөгийг авч 28,1 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

2017 онд банкууд 57,7 мянган иргэд, аж ахуй нэгжид 118,2 тэрбум төгрөгийн зээл олгосны дотор 75 хүнд 2997,1 сая төгрөгийн орон сууцны зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, сая.төг



Өнгөрсөн онтой зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 23,2 хувиар, олгосон зээлийн хэмжээ 4,5 хувиар өсч харин чанаргүй зээлийн хэмжээ 15,5 хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 48,0 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 12 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0,3 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5,9 хувиар, 2015 оны 12-р сарынхаас 10,5 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 11 дүгээр сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 214 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 8,4 хувийнх нь өсч, 2,3 хувийнх нь үнэ буурч, 89,3 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас савласан цэвэр сүү АПУ,бүх ямааны мах,хорхой ааруулын үнэ 2,4- 4,2 хувиар буурч харин бензин А-92,дизелийн түлш,цагаан будаа, иоджуулсан цагаан давс,үхрийн мах,шингэн сүү,масло,шоколад alpen gold 100 гр,алтан тариа 300 гр туузан гоймон үнэ 0,4 – 1,7 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 49,5 хувийнх нь буюу 106 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 1,4 хувийнх нь


буюу 3 нэрийн барааны үнэ буурч, 49,1 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс савласан цэвэр сүү АПУ, цайны 150-180 граммын цайны юбилейные жигнэмэг, өндөгний үнэ 1,4 – 10,2 хувиар буурч, харин хатуу чихэр, цай, давс, тамхи, ундаа, шар, цагаан будаа, алим, элсэн чихэр, сурагчийн цүнх, сурагчийн дөрвөлжин шугамтай дэвтэр, лаа, трико 4-5 настай охидын, хүүхдийн пүүз, эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, даавуу, гэр ахуйн хэрэгсэл, тавилга, оо, саван, тамхи, түлшний мод, парацетамол эм болон даралтны эм, бензин, дизель түлшний үнэ, янжуур тамхи, адууны мах зэрэг барааны үнэ 0,9- 58,3 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ


Аймгийн дүнгээр 2017 оны эцэст 5291,7 мянган мал тоологдсоны дотор 0,02 хувь буюу 1,4 мянга нь тэмээ, 7,2 хувь буюу 381,1 мянга нь адуу, 11,9 хувь буюу 628,8 мянга нь үхэр, 53,8 хувь нь буюу 2845,0 мянга нь хонь, 27,1 хувь буюу 1435,4 мянга нь ямаа байна.



Өнгөрсөн оныхоос нийт малын тоо 5,6 хувиар буюу 282,1 мянган толгойгоор өссөний дотор тэмээ 10,9 хувиар буюу 136 толгойгоор, адуу 6,8 хувиар буюу 24,2 мянган толгойгоор, үхэр 8,2 хувиар буюу 47,6 мянган толгойгоор, хонь 6,6 хувиар буюу 177,0 мянган толгойгоор, ямаа 2,3 хувиар буюу 33,1 мянган толгойгоор тус тус төрөл бүр дээрээ өссөн байна.

Сумдаас Эрдэнэмандал 488,7 мянга, Батцэнгэл 401,3 мянган малтай, Хайрхан (372,7 мянга), Ихтамир(358,5), Өндөрүлаан (348,4), Хашаат (341,1), Хотонт(336,8), Цэцэрлэг(322,6), Цэнхэр(316,6) , Өлзийт(304,3) гэсэн 8 сумд 300-аас дээш мянган малтай, Өгийнуур (291,4), Тариат (265,3), Жаргалант (239,7), Эрдэнэбулган(200,2) гэсэн 4 сумд 200-аас 291,4 мянган малтай, Чулуут (195,0), Төвшрүүлэх(155,3), Булган(133,0), Цахир(111,2), Хангай (109,5) гэсэн 5 сум 100-аас 195,0 мянган толгой малтай байна. Сумд дотроос адуугаар Батцэнгэл(32,8 мянга), Хотонт(30,4), Цэнхэр(30,2), сумд, үхрээр Ихтамир(60,4 мянга), Өндөрүлаан (58,1), Чулуут(52,3) сумд, хониор Эрдэнэмандал(328,7 мянга), Батцэнгэл(227,3), Хашаат(197,6) сумд, ямаагаар Хотонт(119,1 мянга), Хашаат (105,4), Батцэнгэл(105,6) сумд, тэмээгээр Хашаат(462 толгой), Өгийнуур(448 толгой), Өлзийт(310 толгой), сумд тус тус тэргүүлж байна.

Төл бойжилтын хувь



Энэ онд оны эхний хээлтэгч малын 89,0 хувь нь буюу 1903,6 мянган эх мал төллөж гарсан төлийн 94,4 хувь нь буюу 1796,7 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботго 97,1 хувиар, унаганы 94,6 хувь, тугалын 94,7 хувь, хурганы 95,3 хувь, ишигний 92,3 хувь нь бойжиж байна. Сумдаас Хашаат, Өгийнуур, Цэцэрлэг, Өлзийт, Булган сумд гарсан төлөө 98,0-аас дээш хувиар бойжууллаа. 2017 оны эцэст 209 гахай, 68 шувуу, 48 бүл зөгийг иргэд тэжээж бүтээгдэхүүнийг нь авч ашиглаж байна.

2017 оны эцсийн байдлаар малаа жилийн дөрвөн улиралд маллаж мал аж ахуйгаасаа өрхийн орлогын дийлэнхи хэсгийг олж амьдардаг 15160 малчин өрх байгаа нь өмнөх оныхоос 724 өрхөөр нэмэгдсэн байна.

Малчин өрхийн 74,5 хувь нь буюу 11,3 мянга нь цахилгаан гэрэлтэй, 63,9 хувь нь буюу 9,6 мянга нь телевизортой, 8,6 хувь нь радиотой, 39,4 хувь нь буюу 5,9 мянга нь оёдлын машинтай байна.


Аймгийн дүнгээр нийт малчин өрхийн 1,9 хувь нь буюу 284 өрх 10 хүртэл малтай, 5,2 хувь нь буюу 794 өрх 11-30 хүртэл, 5,1 хувь нь буюу 778 өрх 31-50 хүртэл, 11,8 хувь нь 1800 өрх

51-100 хүртэл, 22,7 хувь нь буюу 3442 өрх 101-200 хүртэл, 33,2 хувь нь буюу 5025 өрх 201-500 хүртэл, 14,5 хувь нь буюу 2210 өрх 501-999 хүртэл, 5,5 хувь нь буюу 821 өрх 1000-аас дээш малтай байна. 2016 оныхтой зэрэгцүүлэхэд нийт малчин өрхийн 24,0 хувь нь 100 хүртэл малтай байгаа нь 0,9 пунктээр буурч харин 201-500 малтай өрхийн эзлэх хувь 1,2 пунктээр, 501-ээс дээш малтай өрхийн эзлэх хувь 1,4 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээгээр 1000-аас дээш толгой малтай 821 өрх байгаагийн 47 нь 2001-ээс дээш малтай, 88 нь 1500-2000 малтай, 686 нь 1000-1499 малтай байна.

Энэ онд улс орон нутгийн төсвийн болон төсөл хөтөлбөрийн 353,0 сая төгрөгөөр 30 худаг шинээр гаргаж 18,3 сая төгрөгөөр 10 худгийг засварласан байна.

2017 онд оны эхний мал 97,4 хувиар онд орж оны эхний малын 2,6 хувь буюу 129,5 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 5,8 хувийг адуу, 10,9 хувийг үхэр, 50,5 хувийг хонь, 32,8 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Сумдаас Эрдэнэмандал, Хашаат, Төвшрүүлэх, Хайрхан сумд оны эхний малаа 99,8-98,7 хувиар онд оруулан хамгийн бага хорогдолтой байна. Харин Эрдэнэбулган суманд оны эхний малын 9,1 хувь буюу 17,8 мянган мал, Өндөрүлаан

сумын оны эхний малын 6,9 хувь буюу 22,5 мянган мал, Хотонт суманд оны эхний малын 4,2 хувь буюу 13,2 мянган мал, хорогдсон нь хамгийн их хорогдолтой байна.


Энэ онд аймгийн дүнгээр 7710 га-д үр тариа, 479,6 га-д төмс, 171,9 га-д хүнсний ногоо, 1832,7 га-д малын тэжээлийн ургамал, 1400 га-д техникийн ургамал тус тус тариаллаа.

Өнгөрсөн онтой зэрэгцүүлэхэд тариалсан үр тариа 51,9 хувиар, төмс 2,4 хувиар, хүнсний ногоо 10,7 хувиар, тэжээлийн ургамал 2,7 дахин, техникийн ургамал 2,2 дахин илүү байна.

Аймгийн дүнгээр үр тариа 4401 тн, төмс 2507,7 тн, хүнсний ногоо 754,0 тн, тэжээлийн ургамал 5893 тн, техникийн ургамал 641 тонныг хурааж аваад байна. Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд хураан авсан тэжээлийн ургамал 26,4 хувиар илүү харин хүнсний ногоо 36,7 хувиар, үр тариа 39,8 хувиар, төмс 29,0 хувиар бага байна.

Мөн 51,0 мян.тн байгалийн хадлан, 1052,2 тн гар тэжээл бэлтгэсний дотор сумын аюулгүйн нөөцөнд 490 тн өвс, 104 тн тэжээл нөөцөлсөн байна.

Хураасан үр тариа, төмс, хүнсний ногоо тн-оор,



2017 онд манай аймаг ойгоос 101,3 мянган м3 галын түлээ, 12,7 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 114,0 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас 102,7 мянган м3 галын түлээ, 9,5 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 112,2 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 351,5 сая төгрөг төсвийн орлогод оруулж, ойн зөрчилд 3,6 сая төгрөгийн торгууль, 6,2 сая төгрөгийн нөхөн төлбөр оногдуулсан байна.




АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2017 онд оны үнээр 6213,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 2,4 хувиар бага байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 2243,2 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0,3 хувиар бага байна.

Нийт үйлдвэрлэлтийн 10,9 хувийг хүнс ундааны, 1,3 хувийг хэвлэлийн, 60,9 хувийг дулааны эрчим хүчний, 14,5 хувийг усан хангамж, 4,4 хувийг модон эдлэлийн, 4,8 хувийг гутал хувцасны, 3,2 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэрчсэн гурил, бууз, түгээсэн цэвэр ус, дулаан, монгол гутал, монгол дээл, гэрийн мод, вакум цонх үйлдвэрлэлт 0,4-10,4 хувиар нэмэгдлээ. Харин савласан цэвэр ус, архи, зүсмэл, савхин гутал, гэрийн модон тавилгын үйлдвэрлэлийн хэмжээ 4,9 – 57,2 хувиар буурсан байна.



БАРИЛГА

Барилгын байгууллагууд 9399,1 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 7,8 хувиар буурсан байна. Нийт ажлын 66,8 хувь нь угсралтын ажил 33,2 хувь нь их засварын ажил байна.



ТЭЭВЭР

Тээврийн байгууллагууд 59,0 мянган зорчигч, 28,0 мянган тонн ачаа тээвэрлэн 27,5 сая хүн км, 7,8 сая ткм ажил гүйцэтгэн 620,3 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлтийн хэмжээ 26,7-27,1 хувиар, ачаа эргэлт, тээсэн ачаа 10,1-51,5 хувиар нэмэгдсэн байна.

Холбооны байгууллагууд 408 телефон цэг, улс хот хоорондын телефоны яриа, интернет, телевизийн болон шуудангийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж

сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 349,6 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оныхоос 10,1 хувиар өссөн байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

12 дугаар сард агаарын дундаж температур -9,7-оос -16,2 хэм хүйтэн байсан бөгөөд хамгийн их дулаан Төвшрүүлэх, Цэцэрлэг, Батцэнгэл, Эрдэнэбулган сумдад 2,0 - 3,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Чулуут, Хангай, Өлзийт, Цахир сумдад -27,0-ээс -29,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Тариат, Цэцэрлэг, Цахир сумдын нутгаар 1,3-1,4 мм цас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Батцэнгэл, Өлзийт, Төвшрүүлэх сумдад цас ороогүй байна.

Статистикийн хэлтэс
2018.01.11